



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/940

Мандагновь

Зарцуулах эрх олгох тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.4, 32 дугаар зүйлийн 32.1.1 дахь заалт, "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийн 7¹ дугаар зүйлийн 7^{1.1} дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (ковид-19)-ын халдвараар эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа иргэдийн тоо өсөж эмчилгээний зардал дутагдалтай байгаа нөхцөл байдлыг харгалзан 2021 оны Орон нутгийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр санхүүжигдэхээр батлагдсан "Хөдөөгийн хүн амд сүрьеэ өвчний илрүүлэг, шинжилгээ, оношилгоо хийх төсөл"-ийн 10,000.000 (Арван сая) төгрөг, "Хөдөөгийн хүн амд бэлгийн замаар дамжих халдварын илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх төсөл"-ийн 10,000.000 (Арван сая) төгрөгийг тус тус Коронавируст (ковид-19)-ын халдварын голомтод ажиллаж байгаа эмч, ажилчдын хамгаалах хувцас хэрэглэл, эмчилгээнд шаардлагатай хүчилтөрөгчийн баллон, пос уншигч багаж хэрэгслийн зардалд зарцуулсугай.

2. Шаардлагатай хувцас хэрэглэл, багаж хэрэгслийг нийлүүлэх ажлыг яаралтай зохион байгуулж, дээрх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210937